

## ТАТВАРЫН ХУУЛИЙН ХЭРГЭЖИЛТЭД НӨЛӨӨЛӨХ ХУВЬ ХҮНИЙ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ АРГА ЗАМ

Л.Буяндулам<sup>1</sup>, Т.Ууганбаяр<sup>2</sup>

**Хураангуй:** Татварын хуулийг үл мөрдөх явдал нь аль ч нийгэм эдийн засгийн тогтолцоонд түгээмэл үзэгдэл юм. МУ-ын хувьд ч гэсэн татвар төлөгчдийн татварын хуулийг дагаж мөрдөх хандлага нэлээд сул байсаар байна. Тухайлбал, 2018, Орхон аймгийн статистикийн газар бүртгэлтэй хувиараа бизнес эрхлэгчдийн 32.3 хувь нь л татвар төлөгчөөр бүртгүүлсэн байна.

Түүнчилэн аймгийн татварын хэлтэст бүртгэлтэй ХХОАТ төлөгч иргэдийн 62.8 хувь нь хувиараа бизнес эрхлэгчид, 37.2 хувь нь цалин хөдөлмөрийн хөлсний орлого олж буй иргэд байгаа ч татвар орлогын 99.4 хувийг суутгалын татвар төлөгчид бүрдүүлж байна.

Судлаачдын үзэж байгаагаар хувь хүний татварын хууль тогтоомж дагаж мөрдөх нь түүний татварт хандах хандлагатай ихээхэн хамааралтай байдаг байна. Тухайлбал, татварын хууль тогтоомжийг шүүмжилж буй татвар төлөгчтэй харьцуулахад татварын хууль тогтоомжийг эерэгээр хүлээн зөвшөөрдөг татвар төлөгчийн хувьд татвар төлөх эерэг хандлагатай байна.

Судалгааны мэдээлэл цуглуулахдаа Орхон аймагт хувиараа бизнес эрхэлж буй иргэдийг бизнесийн 13 төрөлд ангилан нийт 330 бизнес эрхлэгчээс түүвэрлэн авсан ба энэ нь Орхон аймгийн статистикийн газар бүртгэлтэй байгаа татвар төлөгчдийн 4.5 хувь нь, татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлсэн бизнес эрхлэгчдийн 14.01 хувь юм. SPSS программыг ашиглан компьютерт бэлтгэн оруулсан бөгөөд мэдээллийн боловсруулалт, статистик шинжилгээнд SPSS программыг ашиглав.

**Түлхүүр үгс:** Татварын хандлага, татвар төлөгч, эерэг хандлага, сөрөг хандлага,

**Abstract:** The non-compliance of the tax law is a common phenomenon in any socioeconomic system. Even in Mongolia, taxpayer's tax compliance attitude is still weak. For example, in 2018, Orkhon Province statistical office registered 32.3 percent of registered self-employed as taxpayers.

For example, In 2018, 32.3 percent of self-employed registered at statistics office in Orkhon Province is registered in a taxpayer in tax office in Orkhon Province.

In addition, 62.8 percent of the personal income taxpayer's who are registered at the tax office of the taxpayers are self-employed and 37.2 percent are withholding income tax, but 99.4 percent of the income tax on personal income tax is the withholding taxpayer.

According to the researchers, compliance with individual tax laws is largely dependent on its taxpayer's tax compliance attitude. For example, taxpayers have a positive tendency to pay taxes on taxpayers with a taxpayer that is

<sup>1</sup> МУИС-ийн Эрдэнэт сургууль, (email) buya812@yahoo.com

<sup>2</sup> МУИС-ийн Эрдэнэт сургууль, (email) t.uugaa0907@gmail.com

positively recognized tax legislation.

Survey data collection was conducted among 330 entrepreneurs in 13 categories of business entrepreneurs in Orkhon Province, which is 4.5 percent of taxpayers registered in Orkhon Province statistical office and 14.01 percent of registered business entities with taxpayers. SPSS software was developed and computerized and SPSS was used for data processing and statistical analysis.

**Key words:** tax laws, tax compliance, tax attitude, tax payer

## Удиртгал

Дэлхийн улс орнуудад татварын татвар ногдуулж, хураах “Татвараа өөрөө тодорхойлон төлөх”, “Татварын алба тодорхойлж төлүүлэх” гэсэн 2 систем хэрэглэж байгаа ба манай улс татвараа өөрөө тодорхойлон төлөх тогтолцоо бүхий улс юм. Татвараа өөрөөр тодорхойлон төлөх аргыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд олон нийтийн татварын талаарх мэдлэг боловсрол өндөр байх, сайн дураараа татварын хууль тогтоомжийг сахих, татварын тайлангаа үнэн зөв гаргаж байх явдал чухал ач холбогдолтой байдаг.

Татварын хуулийг үл мөрдөх буюу татварын зөрчил гаргах явдал нь аль ч нийгэм эдийн засгийн тогтолцоонд түгээмэл үзэгдэл байсаар байна. МУ-ын хувьд ч гэсэн татвар төлөгчдийн татварын хуулийг дагаж мөрдөх хандлага нэлээд сул байсаар байна. Тухайлбал,

Хөгжингүй болон хөгжиж буй улсуудад хийсэн судалгаанаас авч үзвэл хувиараа бизнес эрхлэгчид болон цагийн ажил хийдэг хүмүүс татвараас зайлсхийх хандлага хамгийн өндөр байдаг байна. Мөн хөгжиж буй орнуудын хувьд татвар дайчлах түвшин хөгжиж буй орнуудаас сул байна.

2018 оны байдлаар Орхон аймгийн статистикийн газар бүртгэлтэй хувиараа бизнес эрхлэгч 7284 иргэд байгаагийн ердөө 32.3 хувь нь л татвар төлөгчөөр бүртгүүлсэн байна. Түүнчилэн аймгийн татварын хэлтэст бүртгэлтэй ХХОАТ төлөгч иргэдийн 62.8 хувь нь хувиараа бизнес эрхлэгчид, 37.2 хувь нь цалин хөдөлмөрийн хөлсний орлого олж буй иргэд байгаа ч ХХОАТ-ын орлогын 99.4 хувийг суутгалын татвар төлөгчид бүрдүүлж байна. Энэ нь нэг талаас Орхон аймгийн хэмжээнд бүртгэлгүйгээр үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчид нэлээд байгаа ба бүртгэлтэй татвар төлөгчид ч гэсэн татвараа үнэн зөв тайлагнан төлөхгүй байгааг харуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл иргэдийн татварын хуулийг даган мөрдөх түвшин сул байгааг харуулж байна.

Тиймээс татвар төлөгчдийг татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг хэрхэн дэмжих тухай асуудал нь хөгжингүй буй болон хөгжиж буй орнуудын аль алиных нь засгийн газар, эрдэмтдийн анхаарлыг татаж байна.

Судлаачдын үзэж байгаагаар хувь хүний татварын хууль тогтоомж дагаж мөрдөх нь түүний татварт хандах хандлагатай ихээхэн хамааралтай байдаг байна. Тухайлбал, татварын хууль тогтоомжийг шүүмжилж буй татвар төлөгчтэй харьцуулахад татварын хууль тогтоомжийг эерэгээр хүлээн зөвшөөрдөг татвар төлөгчийн хувьд татвар төлөх эерэг хандлагатай байна.

Эндээс өөрийн улс, орон нутгийн татвар төлөгчдийн татварт хандах хандлага, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар илүү сайн ойлголттой болох нь татвар төлөгч татвараа өөрөө тодорхойлон төлөх системтэй манай улсын хувьд цаашид татварын хэрэгжилтийг сайжруулах гол элемент болох чухал ач холбогдолтой юм.

### **Судалгааны зорилго:**

Орхон аймгийн хувиараа бизнес эрхлэгчдийн татвар төлөх хандлага, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох.

### **Судалгааны зорилт:**

- Орхон аймгийн хувиараа бизнес эрхлэгчдээс татварын хандлагын талаар түүвэр судалгаа авч татварт хандах хандлагыг тодорхойлох
- Орхон аймгийн хувиараа бизнес эрхлэгчдийн татварт хандах хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээг хийх
- Орхон аймгийн болон хөгжингүй болон хөгжиж буй зарим улсын татварын хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийн харьцуулсан судалгааг хийх

### **Сэдвийн судлагдсан байдал:**

Татвар төлөгчийн хууль хэрэгжүүлэх түвшин татвар төлөгчийн хандлагаас ихээхэн хамааралтай гэж үздэг ба татвар төлөгчийн хандлагад олон хүчин зүйл нөлөөлдөг гэж үзэн ОУ-ын хэмжээнд энэ чиглэлд нэлээд судалгаа хийгдсээр байгаа ба 2000 оноос хойш зөвхөн англи хэл дээр албан ёсоор хэвлэгдсэн судалгаа гэхэд л 80 орчим байна. Заримыг дурдвал:

1. Ракиатоу Никанема, Паб Забаяог нар, /2017/, “Сахар орчмын Африкийн татвар төлөгчийн зан төлөв ба институциуд” судалгааны ажилдаа татвар дайчлах түвшин хамгийн багатай бүсийн нэг болох Африкийн сахарын цөлийн 29 улсын татвар төлөгчдийн зан төлөвийг судалж үзсэн ба татварын албаны чадамж сул байгаа байдал нь татвар төлөх эерэг хандлагад сөргөөр нөлөөлдөг гэсэн ерөнхий дүгнэлтэд хүрсэн байна. Гэхдээ энэ үзэгдэл нь 29 бүсэд харилцан адилгүй байна. Мөн төрийн үйлчилгээний чанар, шударга бус байдал зэрэг нь татвар төлөх хандлагад ихээхэн нөлөөлдөг гэсэн үр дүнд хүрсэн байна.

2. Merima Ali, Odd Helge, Fjeldstad, Ingrid Hoem, Sjursen, Chr. Michelsen нар 2013 он, “Татварын хуулийг даган мөрдөх хандлагад нөлөөлөх хүчин зүйлс” судалгааны ажлаа Африкийн тивийн Кень, Танзани, Уганда, Өмнөд Африкийн жишээ дээр хийж гүйцэтгэсэн ба дараах үр дүн бий болсон. Татвараас зайлсхийх нь хүндрэлтэй, мөн төрийн үйлчилгээний чанарт сэтгэл хангалуун байдал татварын ерэг хандлагатай бол нийгмийн угсаатны бүлэгт шударга бус ханддаг байдал /Танзан, амнөд африк/, татварын тухай мэдлэггүй байдал, эрүүгийн гэмт хэргийн бүлэглэлд хэтэрхий их хөрөнгө зарцуулдаг байдал зэрэг нь нэлээд сөрөг хамааралтай байсан.
3. Марк П. Беренсон, доктор, 2007 он, “Польш, Орос, Украин улсууд дахь татварын хуулийг даган мөрдөх хандлага” судалгааны ажилдаа адилхан коммунист гэгдэх дээрх улсуудын иргэдийн засгийн газартаа итгэх итгэл татварт хандах хандлагыг хир ижил байгаа байдалд судалгаа хийсэн ба төдийлөн адил байгаагүй. Өөрөөр хэлбэл итгэл үнэмшил татварт хандах хандлагад нөлөөлдөг гэдэг нь Польш улсын хувьд батлагдсан. Үр дүнтэй засаглалыг бий болгоход иргэдийн итгэлийг олох ёстой мөн татварын албад нь иргэдийн татварт хандах хандлагад эерэгээр нөлөөлөхийн тулд иргэдтэй хамтран ажиллаж, туслалцаа үзүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн.
4. Лариса-Маргарета БЕНЕСКО, Рамона-Анкан НИК ХИНИЙ ИОНГОН БЕСТЕКЕА, Богдан Андрей MOLDOVAN нар “Татварын хуулийг дагаж мөрдөх загвар буюу эдийн засгийн ба зан байдлын хандлага” бүтээлдээ татварыг дагаж мөрдөх загварыг эдийн засаг, зан байдлын үзэл баримтлалд онцлон авч үзсэн. Татварын хуулийг дагаж мөрдөх нь зөвхөн эдийн засгийн хувьд төдийгүй төрийн үйлчилгээний төлбөрийг бий болгох үйл ажиллагаа учраас иргэдийн зан байдалтай холбоотой. Тиймээс засгийн газар, татварын байгууллага хууль боловсруулах болон хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа тэдний зан байдлыг харгалзан үзэх, анхаарал хандуулах ёстой.
5. Тао Зэн, 2014, “Татварын хуулийг дагаж мөрдөх зан төлөвт юу нөлөөлдөг вэ” судалгааны ажлаа хийхдээ татвар төлөгчийн татварын хуулийг даган мөрдөх хандлагад 3 хүчин зүйл голчлон нөлөөлнө гэж таамагласан. Үүнд: Нэгдүгээрт татварын хуулийн тогтолцоо буюу татварын хуулийн нарийн төвөгтэй, хоёрдмол утгатай байдал, шударга байдал, хоёрдугаарт хуулийн хэрэгжилт буюу торгууль шийтгэл, хяналт шалгалт, гуравдугаарт засгийн газрын зардлын төрөл зэрэг юм. Харин үр дүн нь татварын тогтолцоо хамгийн хүчтэй нөлөөлдөг мөн засгийн газрын зардлын төрөл буюу зарцуулалт бас их нөлөөлдөг бол татварын албаны хууль сахиулах, хөндлөнгийн хяналт, торгууль ногдуулах нь хүмүүсийн татварын тайлагнах

үйл ажиллагаанд ноцтой нөлөөлдөггүй гэж үзсэн. Судалгаагаар мөн жендэр болон мэдүүлэг өгөх туршлагаас хамаарч өөр өөр байдаг. Судалгааны материалыг хувь хүний орлогын албан татварын мэдлэгтэй татвар төлөгч хэн гэдгийг мэддэг Канадын бизнесийн болон эдийн засгийн ангийн оюутнуудын хамт цуглуулсан байна.

6. Devos K, Factor's influencing individual taxpayer compliance behavior, 2014  
Абдул, “Татвар төлөгчийн татварын хуулийг даган мөрдөх шийдвэрт нөлөөлөх татвар төлөгчийн хандлагыг үнэлэх нь” 2013, Гана улсын Тамал дахь ЖДҮ-ийн ажилчдыг хамруулан судалгааг хийсэн ба татварын дарамт, татварын хуулийн мэдлэг, нийтийн бараа үйлчилгээний түвшин зэрэг нь татвар төлөх хандлагад хэрхэн нөлөөлдөг тухай судалгааг асуулгын аргаар хийсэн байдаг. Засгийн газрын ил тод байдлын түвшин татварт төдийлөн нөлөөлдөггүй бол, татварын дарамт нь татварын хандлагад ихээхэн нөлөөлдөг тухай ( $R = 0.72$ ) магадлалтайгаар баталсан байна.
7. Манай улсын хувьд энэ төрлийн судалгаа төдийлөн хангалттай хийгдээгүй ба Х. Өлзийгунгалаг, М. Жанухаз нар “Татвар төлөх олон нийтийн хандлага” сэдвийн хүрээнд Сонгино хайрхан дүүргийн 247 иргэдээс асуулга судалгааны аргаар татвар төлөгчийн нас, боловсрол, ажил эрхлэлтээр нь татвар төлөгчийн татварт хандах хандлагыг тодорхойлсон татварын талаарх мэдлэг нь татвар төлөх хандлагатай эерэг хамааралтай мөн татварын талаарх мэдлэггүй байдал нь татвар төлөх хандлагатай сөрөг биш хамааралтай гэж баталсан байна.

Бидний судалгааны ажил нь дээрх судалгаануудад үндэслэн хөгжиж буй болон хөгжингүй орнуудын иргэдийн татвар төлөх хандлагад нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйлс гэж тодорхойлогдсон хүчин зүйлс Орхон аймгийн хувиараа бизнес эрхлэгчдийн хувьд хэрхэн байгааг авч үзсэн явдал юм.

#### **Сэдвийн ач холбогдол:**

Хувиараа бизнес эрхлэгч иргэдийн татвар төлөх хандлагад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох нь татвараа өөрөөр тодорхойлон төлөх хүсэл эрмэлзэлтэй татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн татварын хууль тогтоомж, арга зүй боловсруулахад бодлого боловсруулагчид болон татварын байцаагчдад дэмжлэг материал болох боломжтой.

#### **Судалгааны арга зүй:**

Судалгаанд иргэдийн хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн шинж байдал, татварт хандах хандлага, татвар төлөгчийн мэдлэг, мэдээлэл авч буй байдал зэрэг хэсгүүдээс бүрдсэн асуулгын хуудсыг ашиглалаа.

Асуулга дараах бүтэцтэй. Үүнд:

- a. Хариулагчийн шинж байдал
- b. Татварт хандах хандлагын талаар
- c. Татвар төлөгчийн мэдлэг, мэдээлэл авч буй байдал


Судалгааны мэдээлэл цуглуулахдаа Орхон аймагт хувиараа бизнес эрхэлж буй иргэдийг бизнесийн 13 төрөлд ангилан нийт 330 бизнес эрхлэгчээс түүвэрлэн авсан ба энэ нь Орхон аймгийн статистикийн газар бүртгэлтэй байгаа татвар төлөгчдийн 4.5 хувь нь, харин татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлсэн бизнес эрхлэгчдийн 14.01 хувь юм. SPSS программыг ашиглан компьютерт бэлтгэн оруулсан бөгөөд мэдээллийн боловсруулалт, статистик шинжилгээнд SPSS программыг ашиглав.

### Сэдвийн тоон өгөгдөл:

Бид энэхүү судалгааг тоон судалгааны аргаар хийсэн бөгөөд эх олонлогийн онцлогоос хамаарч магадлалт, давхаргат санамсаргүй түүврийн аргыг ашигласан.

Түүврийн эх олонлогийг Орхон аймгийн албан ёсны статистик мэдээллээс хувиараа бизнес эрхэлдэг 7284 иргэн хамруулан 95%-ийн итгэх магадлалтай,  $\pm 5\%$ -ийн алдааны хязгаартай байхаар 330 хувиараа бизнес эрхлэгчийг магадлалт, давхаргат санамсаргүй түүврийн аргаар сонгон татварын хандлагын талаар нийт 3 хэсэг бүхий 35 асуумжаас бүрдсэн асуулгаар тоо мэдээллийг цуглуулсан.

**Зураг 1.** Судалгаанд хамрагдсан хувиараа бизнес эрхлэгч, үйл ажиллагааны чиглэлээр



Хувиараа бизнес эрхлэгчдийг магадлалт, давхаргат санамсаргүй түүврийн аргыг ашиглан түүвэрлэхдээ хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан орлогыг нь тодорхойлох боломжгүй иргэдийн үйл ажиллагааны чиглэл

бүрээс пропорциональ байхаар давхаргат түүврийн хэмжээг тодорхойлсон. Бидний судалгаанд хамрагдсан нийт 330 хувиараа бизнес эрхлэгчийн 4.2% нь цахилгаан ба хийн гагнуур, хөрөө рам, дарханы үйлчилгээ, 4.5% нь авто машины засвар үйлчилгээ, машин угаалга, дугуй засварын үйлчилгээ, 4.8% гэр ахуйн бараа, худалдаа, 14.8% бэлэн хувцасны худалдаа гэх мэт хувиараа бизнес эрхлэгчид хамрагджээ.

## ОРХОН АЙМГИЙН ХУВИАРАА БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ТАТВАРЫН ХАНДЛАГАД ХИЙСЭН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Онолын хувьд татварын хандлага нь 6 бүлэг хүчин зүйлсээс хамаардаг гэж үзсэн тул бид судалгааны энэ хэсэгт татварын хандлагад нөлөөлдөг 6 бүлгийг нэг бүрчлэн авч үзлээ.

### Хүснэгт 1. Хувиараа бизнес эрхлэгчийн татварын хандлага болон нийгэм, хүн ам зүйн хүчин зүйлс

№	Асуулт		Татварын хандлага	
			Сөрөг хандлага	Эерэг хандлага
1	Хүйс	Эр	41.76%	58.24%
		Эм	47.70%	52.30%
2	Гэрлэлтийн байдал	Гэрлэсэн	46.21%	53.79%
		Гэрлээгүй/ ганц бие/	45.10%	54.90%
		Гэр бүлгүй/аав, ээж, эмээ, өвөө/	50.00%	50.00%
3	Боловсрол	Бага болон суурь	41.67%	58.33%
		Бүрэн дунд	45.36%	54.64%
		Техник мэргэжлийн	45.00%	55.00%
		Дээд	48.08%	51.92%
4	Мэргэжил	Бизнесийн удирдлага	42.31%	57.69%
		Инженер	43.48%	56.52%
		Багш	43.48%	56.52%
		Эмч	42.86%	57.14%
		Хуульч	33.33%	66.67%
5	Нас	Бусад	47.18%	52.82%
		30 хүртэл	46.84%	53.16%
		31-45 нас	50.00%	50.00%
		46-59 нас	40.38%	59.62%
		60-аас дээш	47.06%	52.94%

Хувиараа бизнес эрхлэгчдийг нийгэм, хүн ам зүйн хүчин зүйлсээс нь хамааруулан авч үзэхэд татварын эерэг болон сөрөг хандлагад нас, хүйс, боловсрол, мэргэжил, бараг ялгаагүй нөлөө үзүүлдэг байж болзошгүй байна.

Тухайлбал, судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 58.24%, эмэгтэйчүүдийн 52.3% нь эерэг хандлагатай. Харин боловсролын түвшин нэмэгдэхэд татварын сөрөг хандлага нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл бага болон суурь боловсролтой хувиараа бизнес эрхлэгчдийн 41.67% нь, дээд боловсролтой хувиар бизнес эрхлэгчийн 48.08% нь сөрөг хандлагатай байна. Эндээс харахад иргэдийн боловсролын түвшин ахих тусам иргэд татвараас зайлсхийх, хууль тогтоомжийг дагаж мөрдөхгүй байх тохиолдол нэмэгддэг байна.

Эзэмшсэн мэргэжлийг нь аваад үзвэл хуульч нар татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх (сөрөг хандлага 33.3%) нь илүү байдаг бол бусад мэргэжлийн хувьд татварын сөрөг хандлага дунджаар 43%, эерэг хандлага нь 57% байна. Насны хувьд 46-59 насны хувиараа бизнес эрхлэгчдийн татварын эерэг хандлага хамгийн өндөр буюу 59.62% байхад 60-аас дээш насныхны сөрөг хандлага хамгийн өндөр(47.06%) байна.

### Хүснэгт 2. Хувиараа бизнес эрхлэгчдийн татварын хандлага ба ЭЗ-ийн хүчин зүйлс

№	Асуулт			Татварын хандлага		
				Сөрөг хандлага	Эерэг хандлага	
1	Өрхийн орлого	500,000 төгрөг хүртэл		50.4%	49.6%	
		500,001 - 1000,000 төгрөг		46.8%	53.2%	
		1000,001 - 2000,000 төгрөг		34.1%	65.9%	
		2000,001 - 5000,000 төгрөг		41.2%	58.8%	
		5000,001 - 10,000,000 төгрөг		25.0%	75.0%	
		10 сая төгрөгөөс дээш		33.3%	66.7%	
2	Таны бодлоор татвараас зайлсхий хялбархан уу?	Маш хялбар		100.0%	0.0%	
		Хялбар		61.5%	38.5%	
		Хэцүү		43.9%	56.1%	
		Маш хэцүү		48.3%	51.7%	
		мэдэхгүй		33.3%	66.7%	
3	Татварын хувь хэмжээ өндөр үү?	Тийм		49.3%	50.7%	
		Үгүй		43.5%	56.5%	
№	Асуулт	Хувийн	Түрээсийн	Лизинг	Бусдынх	Байхгүй
1	Орон сууц	37.1%	2.8%	3.9%	3.4%	52.8%
2	Та хашаа байшин	56.2%	2.8%	2.8%	38.2%	-



3	Авто машин	47.8%	0.6%	1.7%	0.6%	49.4%
4	Зуслангийн байшин	10.1%	-	-	0.6%	89.3%

Эдийн засгийн хүчин зүйлсэд өрхийн орлого, татварын хувь хэмжээ, хөрөнгө, татвараас зайлсхийх нь хялбар байдаг эсэх гэсэн 4 хүчин зүйлийг авч үздэг. Өрхийн орлого өсөх тусам татварын эерэг хандлага нэмэгдэх хандлагатай бол сөрөг хандлага буурч байна. Татварын хувь хэмжээг өндөр гэж үздэг хувиараа бизнес эрхлэгчдийн 50.7% нь татварын эерэг хандлагатай бол өндөр биш гэж үздэг бизнес эрхлэгчдийн 56.5% нь эерэг хандлагатай байжээ.

Манай татварын тухай хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг зөрчих буюу татвараас зайлсхийх нь хялбар гэж үздэг хувиараа бизнес эрхлэгчдийн татварын сөрөг хандлага өндөр байна. Тухайлбал, татвараас зайлсхийх маш хялбар гэж үздэг хувиараа бизнес эрхлэгчид 100% татварын сөрөг хандлагатай бол маш хэцүү гэж үздэг хувиараа бизнес эрхлэгчийн 48.3% нь татварын сөрөг хандлагатай, 51.7% эерэг хандлагатай. Эндээс харвал хууль тогтоомжийн хэрэгжилт, хуулийн хариуцлага өндөр нь байх иргэдийн татварын хандлагыг эерэг болгоход маш хүчтэй нөлөө үзүүлж болохоор байна. Харин хөрөнгийн хувьд хөрөнгө нь өөрийнх буюу хувийнх гэж хариулсан бизнес эрхлэгчдийн татварын хандлага эерэг байх магадлал өндөр байна.

### Хүснэгт 3. Хувиараа бизнес эрхлэгчдийн татварын хандлага ба хувь хүний дотоод хүчин зүйлс

№	Асуулт	Татварын хандлага		
		Сөрөг хандлага	Эерэг хандлага	
1	Та хэр эх оронч хүн вэ?(1-5 оноогоор үнэлнэ үү? Хэрвээ эх оронч бол 5 оноо, үгүй бол 1 оноо)	Маш бага	40.0%	60.0%
		Бага	42.9%	57.1%
		Дунд	57.9%	42.1%
		их	34.5%	65.5%
	Маш их	46.3%	53.7%	
2	Та шашин шүтдэг үү?	Тийм	48.9%	51.0%

Тухайн бизнес эрхлэгчийн дотоод хүчин зүйлс буюу сэтгэл хөдлөл, шашин шүтлэг, эх оронч байдал нь татварын хандлагад хүчтэй нөлөө үзүүлдэг байна. Орхон аймгийн хувиараа бизнес эрхлэгчдийн хувьд эх оронч байдал болон татварын хандлага нь ямар нэгэн хамааралгүй байж болохоор байна. Өөрөөр хэлбэл эх оронч биш хүмүүсийн 60% эерэг хандлагатай бол эх оронч байдал нэмэгдэхэд татварын эерэг хандлага буурч байгаад эргээд өссөн. Эндээс харахад иргэд өөрсдийнхөө эх оронч үзлийг хэрхэн, яаж тодорхойлж

байгаа нь өөр, өөр учир ийм үр дүнг харуулж байж болох юм. Харин шашин шүтдэг хүмүүс нь шашин шүтдэггүй хүмүүстэй харьцуулахад татварын эерэг хандлагатай байж болохоор байна.

**Хүснэгт 4.** Хувиараа бизнес эрхлэгчдийн татварын хандлага ба нийгмийн нөлөө

№	Асуулт	Татварын хандлага		
		Сөрөг хандлага	Эерэг хандлага	
1	Таныг ялгаварлан гадуурхах хандлага байдаг уу?	Хэзээ ч тохиолдож байгаагүй	45.7%	54.3%
		Хааяа тохиолддог	46.7%	53.3%
		Заримдаа тохиолддог	100.0%	0.0%
2	Хүмүүс татвараас хэр их зайлсхийдэг вэ?	Хэзээ ч үгүй эсвэл ховор	45.3%	54.7%
		Ихэвчлэн эсвэл байнга	50.0%	50.0%
3	Таны татварын албанд итгэх итгэл хэр вэ?	Маш муу	68.8%	31.3%
		Муу	59.7%	40.3%
		Дунд зэрэг	41.7%	58.3%
		Сайн	36.4%	63.6%
		Маш сайн	85.7%	14.3%
4	Та татварын байцаагчдыг авилгал хэр авдаг гэж боддог вэ?	Огт авдаггүй	48.9%	51.1%
		Цөөхөн хэд нь авдаг	41.7%	58.3%
		Зарим нь авдаг	40.0%	60.0%
		Ихэнхи нь авдаг	65.6%	34.4%
		Бүгд авдаг	16.7%	83.3%

Орхон аймгийн хувиараа бизнес эрхлэгчдийн хувьд шашин шүтлэг, яс үндэс, арьс өнгө, нийгмийн гарал гэх мэт зүйлсээр ялгаварлан гадуурхах явдал байнга тохиолддоггүй ба хааяа болон заримдаа тохиолддог байна. Заримдаа тохиолддог хариулагчид 100% татварын сөрөг хандлагатай бол хааяа болон огт тохиолддоггүй хариулагчдын 50 гаруй хувь нь татварын эерэг хандлагатай гэж хариулжээ.

Бусад бизнес эрхлэгчдийг татвараас байнга зайлсхийдэг гэж боддог хариулагч нарын 50% нь татварын эерэг хандлагатай бол үлдсэн 50% нь сөрөг хандлагатай. Хариулагчдын татварын албанд итгэх итгэл, татварын байцаагчдыг авилгалд өртдөг гэсэн бодол нь татварын хандлагатай шууд хамааралгүй байж болох юм. Учир нь татварын байцаагчдыг авилга авдаг гэсэн бодол болон татварын албанд итгэх итгэл муудахад татварын сөрөг хандлага шууд нэмэгдэхгүй байгаа нь бидний судалгааны үр дүнгээс харагдаж байна.

**Хүснэгт 5.** Хувиараа бизнес эрхлэгчдийн татварын хандлага ба засгийн газрын хариу үйлдэл

№	Асуулт	Татварын хандлага		
		Сөрөг хандлага	Эерэг хандлага	
1	Та хүрээлэн буй орчин, зам, цахилгаан эрчим хүч, усан хангамж, шуудан холбоонд хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?	Сэтгэл ханамж маш муу	70.37%	29.63%
		Сэтгэл ханамжгүй	43.07%	56.93%
		Сэтгэл ханамжтай	47.06%	52.94%
		Сэтгэл ханамж маш сайн	12.50%	87.50%
2	Та боловсролын болон эрүүл мэндийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байдаг вэ?	Сэтгэл ханамж маш муу	47.83%	52.17%
		Сэтгэл ханамжгүй	45.61%	54.39%
		Сэтгэл ханамжтай	44.90%	55.10%
		Сэтгэл ханамж маш сайн	66.67%	33.33%
3	Гэмт хэрэг, зөрчил, троризим, авлига зэргийн илрүүлэлтэд хэр сэтгэл хангалуун байдаг вэ?	Сэтгэл ханамж маш муу	50.00%	50.00%
		Сэтгэл ханамжгүй	44.23%	55.77%
		Сэтгэл ханамжтай	48.89%	51.11%
		Сэтгэл ханамж маш сайн	37.50%	62.50%
4	Ерөнхийлөгч, ерөнхий сайд, засгийн газар, орон нутгийн удирдлагуудын үйл хэрэгтэй хир санал нийлдэг вэ?	Огт санал нийлэхгүй	54.90%	45.10%
		Санал нийлэхгүй	40.00%	60.00%
		Зарим талаар салал нийлнэ	42.75%	57.25%
		Санал нийлнэ	55.00%	45.00%
		Бүрэн санал нийлнэ	50.00%	50.00%
5	Та Монгол улс ардчилсан улс гэдэгтэй хэр санал нийлдэг вэ?	Огт санал нийлэхгүй	53.13%	46.88%
		Санал нийлэхгүй	40.59%	59.41%
		Зарим талаар салал нийлнэ	41.18%	58.82%
		Санал нийлнэ	53.09%	46.91%
		Бүрэн санал нийлнэ	58.33%	41.67%

Татвар төлөгчийн төлсөн татварын орлогоор засгийн газар боловсрол, эрүүл, мэнд, гэмт хэргийн эсрэг зардалд зарцуулах замаар иргэддээ үнэгүй боловсрол эзэмшүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламжийг үнэгүй өгөх, аюулгүй тайван орчинд амьдруулдаг байна.

Тиймээс засгийн газрын нийгэмд үзүүлж буй хариу үйлдэлд иргэд хир сэтгэл ханамжтай байгаагаас шалтгаалан татварын хандлага хамаарч байдаг. Орхон аймгийн хувьд иргэдийн амьдарч буй хүрээлэн орчин (гудамжны гэрэлтүүлэг, ногоон байгууламж гэх мэт), эрчим хүч, усан хангамж, шуудан холбоо зэрэгт сэтгэл ханамж муу гэсэн хариулагчдын татварын хандлага сөрөг

гарсан бол сэтгэл ханамж өсөхийн хэрээр татварын сөрөг хандлага буурч, эерэг хандлага өсжээ. Үүнтэй адил боловсрол, эрүүл мэнд, гэмт хэрэг, терроризм, авилга зэргийн илрүүлэлтэд сэтгэл ханамж муу бол татварын хандлага сөрөг, сэтгэл ханамж сайн бол татварын хандлага эерэг байгаа нь бидний судалгааны үр дүнгээр батлагдлаа. Мөн ерөнхийлөгч, ерөнхий сайд, засгийн газар, орон нутгийн удирдлагуудын үйл хэрэгтэй санал нийлдэг, тэдний үйл ажиллагаа дэмждэг бол татварын хандлага эерэг, дэмждэггүй бол сөрөг хандлагатай байгаа нь харагдаж байна.

**Хүснэгт 6.** Хувиараа бизнес эрхлэгчдийн татварын хандлага ба татварын мэдлэг

№	Асуулт	Татварын хандлага		
		Сөрөг хандлага	Эерэг хандлага	
1	Татвар төлөх нь таны үүрэг гэдгийг мэдэх үү?	Мэднэ	45.89%	54.11%
		Мэдэхгүй	50.00%	50.00%
2	Таны төлсөн татварын хариуд таньд нийгмийн үйлчилгээ үнэ төлбөргүй байдгийг мэддэг үү?	Мэднэ	45.35%	54.65%
		Мэдэхгүй	46.84%	53.16%
3	Та өөрөө татвараа тодорхойлж төлж чадах уу?	Чадна	42.72%	57.28%
		Чадахгүй	52.14%	47.86%
4	Та бизнесийн үйл ажиллагаандаа татварыг 10%-иар төлөх ёстойгоо мэдэх үү?	Мэднэ	44.40%	55.60%
		Мэдэхгүй	52.11%	47.89%
5	Та хувийн бизнесийнхээ татвар, тайлангаа хэзээ, хэрхэн төлж, тайлагнахаа мэдэх үү?	Мэднэ	44.93%	55.07%
		Мэдэхгүй	48.54%	51.46%
6	Таньд татварын албанаас татварын тайлан гаргаж, татвар төлөхтэй холбоотой зөвлөгөө өгдөг үү?	Өгдөг	47.02%	52.98%
		Өгдөггүй	45.06%	54.94%

Татварын хандлага эерэг байхад нөлөө үзүүлдэг нэг гол хүчин зүйлс нь татварын талаарх мэдлэг юм. Татварын мэдлэг муугаас шалтгаалан санамсаргүйгээр татвараас зайлсхийх тохиолдол нэлээд гардаг. Бидний судалгаанд хамрагдсан 330 бизнес эрхлэгчийн хувьд татварын мэдлэг боломжийн буюу судалгаанд хамрагдсан хувиараа бизнес эрхлэгчийн дундаж мэдлэг 71% гарсан. Татварын талаарх мэдлэг сайн иргэдийн татварын хандлага эерэг бол мэдлэг муутай иргэдийн татварын хандлага нь сөрөг байх хандлагатай байна. Тухайлбал, татвар төлөх үүрэгтэй гэдгээ мэддэг иргэдийн 45.89% нь сөрөг хандлагатай байхад 54.11% нь эерэг хандлагатай, төлсөн татварын хариуд нийгмийн үйлчилгээ үнэ төлбөргүй авдаг гэдгээ мэддэг хариулагчдын

45% нь сөрөг хандлагатай байхад 55% нь эерэг хандлагатай, татвараа өөрөө тодорхойлж төлж чаддаг иргэдийн 43% нь сөрөг хандлагатай бол 57% нь эерэг хандлагатай гэсэн үр дүнгүүд гарсан юм.

## **ОРХОН АЙМГИЙН ХУВИАРАА БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ТАТВАРЫН ХАНДЛАГАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ**

Судалгааныхаа энэхүү хэсэгт судалгаанд хамрагдсан 330 хувиараа бизнес эрхлэгчдийн татварын хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээг ложит загвар ашиглан хийлээ. Уг загвараар үнэлгээ хийхдээ хамааран хувьсагчаар нэгдүгээрт, татварын хандлагыг сонгон авч сөрөг хандлагатай хариулагчид “0” үнэлгээ, эерэг хандлагатай хариулагчид “1” гэсэн үнэлгээ өгсөн. Хамааран хувьсагчаар онолын хувьд татварын хандлагад нөлөөлдөг 6 бүлгийн 35 хувьсагчийг авч үзсэн болно. Хоёрдугаарт, хамааран хувьсагчаар татвараас зайлсхийж байсан эсэхийг сонгон авсан. Ингэхдээ татвараас зайлсхийж байсан бол “0”, татвараас зайлсхийж байгаагүй бол “1” гэсэн үнэлгээ өгч мөн дээрхтэй адил 6 бүлгийн 35 хувьсагчийг үл хамааран хувьсагчаар сонгон авч загвараа үнэлсэн. Эцэст нь загварын үр дүнг бусад хөгжингүй болон хөгжиж буй улсуудын ложит загвараар үнэлсэн үнэлгээний үр дүнтэй харьцуулан дүгнэлт хийлээ.

$$Y_i(\text{магадлал}) = \beta_0 + \beta_1 SD + \beta_2 EF + \beta_3 IM + \beta_4 PI + \beta_5 R + \beta_6 K + \varepsilon_i$$

Хамааран хувьсагчийг нэгдүгээрт, татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх хандлага(ТСА), хоёрдугаарт, татвараас зайлсхийсэн эсэхийг авсан(АТ). *SD нь нийгмийн болон хүн ам зүйн хүчин зүйлс:* Нас(q5), хүйс(q6), гэрлэлтийн байдал(q7), боловсролын түвшин(q8), мэргэжил(q9); *EF нь эдийн засгийн хүчин зүйлс:* Бизнесийн орлого(q12), татвараас зайлсхийлт хялбар байдаг эсэх(q15), татварын хувь хэмжээ өндөр эсэх(q25\_2), орон сууцны эзэмшил(q10\_1), хашаа байшинтай эсэх(q10\_2), авто машинтай эсэх(q10\_3), зуслангийн байшинтай эсэх(q10\_4); *IM нь хувь хүний дотоод хүчин зүйлс:* Шашин шүтлэг(q13), эх оронч үзэл(q14); *PI нь нийгмийн нөлөө:* арьс өнгө, шашин шүтлэг, яс үндэс, нийгмийн гарлаар ялгаварлан гадуурхдаг эсэх(q19), хүмүүс татвараас зайлсхийдэг эсэх(q20), татварын албанд итгэх итгэл(q21), татварын байцаагчдыг авлага авдаг эсэх талаар бодол (q22); *R нь засгийн газрын хариу үйлдэл:* Хүрээлэн буй орчин, зам, цахилгаан эрчим хүч, усан хангамж, шуудан холбоонд сэтгэл ханамжтай байдаг эсэх(q16), боловсролын болон эрүүл мэндийн үйлчилгээнд сэтгэл ханамжтай байдаг эсэх(q17), гэмт хэрэг, зөрчил, троризим, авилга зэргийн илрүүлэлтэд сэтгэл хангалуун байдаг эсэх(q18), ерөнхийлөгч, ерөнхий сайд, засгийн газар,

орон нутгийн удирдлагуудын үйл хэрэгтэй санал нийлдэг эсэх(q23), Монгол улс ардчилсан улс гэдэгтэй санал нийлдэг эсэх(q24); **К нь хувиараа бизнес эрхлэгчдийн татварын мэдлэг (q28)**, татварын зөвлөгөө авдаг эсэх(q33), татварын талаар мэдээлэл авдаг эсэх(q34);

Дээрх үл хамааран хувьсагчдад дараах хувьсагчдыг чанарын хувьсагчаар оруулсан болно. Үүнд, хүйс (Эмэгтэй-0, эрэгтэй-1), мэргэжил (бизнесийн удирдлага-1, бусад-0, инженер-1, бусад-0 гэх мэт), орон сууц (хувийнх-1, бусад-0), хашаа байшин (хувийнх-1, бусад-0), автомашин (хувийнх-1, бусад-0), зуслангийн байшин (хувийнх-1, бусад-0), бусад бизнес эрхлэгчдийг татвараас зугтаадаг гэж боддог бол (ихэвчлэн эсвэл байнга зугтаадаг-0, хааяа эсвэл хэзээ үгүй -1), татварын албанаас зөвлөгөө авдаг эсэх (зөвлөгөө авдаг-1, авдаггүй-0).

Хувьсагчдын хоорондын хамаарлын хүчийг тооцож үзвэл өндөр хамаарал бүхий хувьсагч байхгүй ба хамгийн өндөр хамаарал нь модулиараа 0.56 байсан. /Хавсарлт 1-т харуулав/ Тиймээс цаашдаа бүх хувьсагчдыг үнэлгээнд хамруулсан болно.

### Хүснэгт 7. Ложит загварын үр дүн

Хувьсагчид	Татвараас зайлсхийх		Татварын хандлага		
	Коэфф	Магадлал	Коэфф	Магадлал	
<b>Нийгэм хүн ам зүйн хүчин зүйлс</b>					
Q5	Нас	-0.034541	0.235	0.009633	0.8909
Q6	Хүйс	0.131635	0.8402	-0.398794	0.1728
Q7	Гэрлэлтийн байдал	0.055901	0.8382	0.098659	0.4419
Q8	Боловсрол	-0.265515	0.3861	0.094021	0.4873
q9_1	Мэргэжил: БУ	-	-	2.607966	0.1000*
Q9_2	Мэргэжил: Инженер	7.314802	0.0427**	2.616404	0.0484**
Q9_3	Мэргэжил: Багш	6.882077	0.0685*	2.781857	0.0846**
Q9_4	Мэргэжил: Эмч	-	-	2.255133	0.198
Q9_5	Мэргэжил: Хуульч	7.721586	0.0348**	2.914643	0.0631*
<b>Эдийн засгийн хүчин зүйлс</b>					
Q12	Орлого	0.18645	0.4926	-0.294646	0.0348**
Q15	Татвараас зайлсхийх хялбар эсэх	-1.737251	0.0012***	-0.429741	0.0985*
Q25_2	Татварын хувь хэмжээ өндөр эсэх	-0.064746	0.9285	0.058615	0.8585
Q10_1	Хувийн өмч: Орон сууц	0.17002	0.7834	0.465172	0.1198
Q10_2	Хувийн өмч: Хашаа байшин	-0.152657	0.8012	-0.048757	0.8632
Q10_3	Хувийн өмч: Автомашин	-0.601977	0.2966	-0.048616	0.8534
Q10_4	Хувийн өмч: Зуслангийн байшин	-0.840745	0.5232	-0.860211	0.1000*
<b>Хувь хүний дотоод хүчин зүйлс</b>					

Q13	Шашин шүтлэг	-0.691357	0.2639	0.113025	0.6593
Q14	Эх оронч байдал	0.030999	0.9186	-0.025185	0.8467

**Нийгмийн нөлөө**

Q19	Ялгаварлан гадуурхдаг эсэх	-0.062183	0.9466	0.284676	0.5474
Q20	Татвараас зайлсхийдэг эсэх	-0.612546	0.194	-0.258593	0.0914*
Q21	Татварын албанд итгэх итгэл	-0.185859	0.5492	0.412798	0.0056***
Q22	Татварын байцаагчдын авилгал авдаг гэж боддог эсэх	-0.280415	0.1409	-0.031516	0.6836

**Засгийн газрын хариу үйлдэл**

Q16	Дэд бүтцэд сэтгэл ханамжтай эсэх	-0.184604	0.6393	-0.655902	0.0012***
Q17	Боловсрол, эрүүл мэндэд сэтгэл ханамжтай эсэх	-0.371795	0.3086	0.316957	0.0866*
Q18	Гэмт хэрэг, авилга гэх мэт зүйлсийг илрүүлж буй байдалд сэтгэл ханамжтай эсэх	0.397723	0.2253	-0.091773	0.536
Q23	Улс төрчид, эрх баригч нарын үйл хэрэгтэй санал нэгддэг эсэх	0.282253	0.2684	0.071359	0.5766
Q24	Ардчилсан улс гэдэгтэй санал нийлдэг эсэх	-0.418187	0.1259	0.190752	0.1176

**Татварын талаарх мэдлэг, мэдээлэл**

Q28	Татварын талаарх мэдлэг	1.17345	0.3282	0.698069	0.0211**
Q33	Татварын албанаас зөвлөгөө авдаг эсэх	0.456387	0.4882	0.411478	0.1913
Q34	Татварын талаар мэдээлэл авдаг эсэх	-0.768673	0.1539	0.007805	0.9731

\*10%-ийн ач холбогдолын түвшин, \*\*5%-ийн ач холбогдолын түвшин,  
\*\*\*1%-ийн ач холбогдолын түвшин

Судалгааны үр дүнгээс харахад зарим хувьсагчид 1%, 5%, 10%-ийн ач холбогдлын түвшинд нөлөө үзүүлдэг байна. Татвараас зайлсхийлт болон татварын хандлагад үзүүлж буй хувьсагчид нэлээд ялгаатай байна. Хариулагчийн эзэмшсэн мэргэжил болон татвараас зайлсхийхэд хялбар байдаг эсэх гэсэн хувьсагчид дээрх 2 загварт 2-ланд нь нөлөөтэй байна. Эндээс харвал хувиараа бизнес эрхлэгчид татварын хууль тогтоомжийн хариуцлагын систем сул байвал татвараас зайлсхийх явдал их байхыг илтгэж байна. Тиймээс татварын хуульд татвараас зайлсхийх боломжийг хязгаарлаж, татвараас зайлсхийсэн тохиолдолд хариуцлагын тогтолцоог чангаруулах нь зүйтэй юм.

Бид цаашдаа судалгааныхаа зорилгодоо нийцүүлэн татварын хандлагад

нөлөөлөх хүчин зүйлсийг илүү тодорхой болгох, хувиараа бизнес эрхлэгчдийн татварын эерэг хандлагатай байх магадлалыг тооцох үүднээс дээрх загвараас хамааралгүй хувьсагчдыг хасч тооцлоо.

Хүснэгт 8. Татварын хандлагад нөлөөлөх хүчин зүйлс,  
ложит загварын үр дүн

<b>Хувьсагчид</b>		<b>Коэффициент</b>	<b>Магадлал</b>
<b>Нийгэм хүн ам зүйн хүчин зүйлс</b>			
q9_1	Мэргэжил: БУ	3.33757	0.0015***
Q9_2	Мэргэжил: Инженер	3.24277	0.0015***
Q9_3	Мэргэжил: Багш	3.54526	0.001***
Q9_4	Мэргэжил: Эмч	3.18929	0.0095***
Q9_5	Мэргэжил: Хуульч	3.58773	0.0002***
<b>Эдийн засгийн хүчин зүйлс</b>			
Q12	Орлого	0.266972	0.0426**
Q15	Татвараас зайлсхийх хялбар эсэх	0.422387	0.0878*
Q10_1	Хувийн өмч: Орон сууц	0.54856	0.0324**
Q10_4	Хувийн өмч: Зулсангийн байшин	-0.933426	0.0601*
<b>Нийгмийн нөлөө</b>			
Q20	Бусад хүмүүс татвараас зайлсхийдэг эсэх	0.227255	0.0197**
Q21	Татварын албанд итгэх итгэл	0.335831	0.0131**
<b>Засгийн газрын хариу үйлдэл</b>			
Q16	Дэд бүтцэд сэтгэл ханамжтай эсэх	0.576919	0.002***
Q17	Боловсрол, эрүүл мэндэд сэтгэл ханамжтай эсэх	0.33972	0.0478**
<b>Татварын талаарх мэдлэг, мэдээлэл</b>			
Q28	Татварын талаарх мэдлэг	0.282405	0.04521**

Түүвэрт татварын сөрөг хандлагатай 152, эерэг хандлагатай 178 хувиараа бизнес эрхлэгч хамрагдсан ба нөлөөлж буй хүчин зүйлс нь 6 бүлгийн 31 хувьсагчаас 5 бүлгийн 14 хувьсагч нөлөөтэй гарлаа. Хувь хүний дотоод хүчин зүйлстэй холбоотой шашин шүтлэг, эх оронч байдал нь Орхон аймгийн хувиараа бизнес эрхлэгчдийн татварын хандлагад нөлөөлөхгүй байна. Эх оронч гэж өөрсдийгөө тодорхойлж буй хариулагчид татварын хандлагын талаар тодорхой үзэл бодолгүй байгаатай холбоотой юм. Мөн шашин шүтлэг нь хүнийг төлөвшүүлэх, хууль бус зүйл хийх сэтгэлгээг бий болгож чадахгүй байгаа нь уг судалгааны үр дүнгээр харагдаж байна.

Судалгаанд татварын сөрөг хандлагатай гэж хариулсан 152 хариулагчийн эерэг хандлагатай болох магадлал дунджаар 48.5% бол эерэг хандлагатай



гэж хариулсан 178 хариулагчийн эерэг магадлалтай байх магадлал дунджаар 78.9% байна.

Загварын үр дүнгээс дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

1. *Орлого нэмэгдэхэд татварын хандлага эерэг болох магадлал нэмэгддэг.*  
Судалгааны үр дүнгээс харвал хувиараа бизнес эрхлэгчдийн татварын орлого өсвөл татварын хандлага эерэг болох магадлал өсч байна. Тухайлбал 500, хүртэл орлоготой хувиараа бизнес эрхлэгчийн татварын хандлага эерэг болох магадлал 48.7% бол 2 сая - 5 сая төгрөгийн орлоготой хувиар бизнес эрхлэгчийн татварын хандлага эерэг болох магадлал 67.7% болж байна. Харин 5000,0 төгрөгөөс дээш орлоготой хувиараа бизнес эрхлэгчийн татварын хандлага эргээд буурсан байгаа нь магадгүй татвараас зайлсхийх нь татвар төлөхөөс илүү эдийн засгийн хувьд үр ашигтай байж болох юм.
2. *Татварын хууль, тогтоомж чанга байх нь татварын эерэг хандлагыг бий болгодог.*  
Татвараас зайлсхийх нь маш хялбар байдаг гэж үздэг хариулагчдын хувьд татварын хандлага эерэг болох магадлал хамгийн бага буюу 33.7% байгаа бол маш хэцүү гэж боддог хариулагчийн хувьд татварын хандлага эерэг болох магадлал 65.6% байна. Тиймээс татварын хууль, тогтоомжийг зөрчсөн хувиараа бизнес эрхлэгчдэд тооцох хариуцлага чанга байх тусам татвараас зайлсхийх, зугтаах магадлал буурах сайн талтай байна.
3. *Хувийн хөрөнгө нэмэгдэх нь татварын хандлагад эерэг болон сөрөг нөлөө үзүүлдэг.*  
Хувиараа бизнес эрхлэгчид нь хувийн орон сууцтай болоход татварын эерэг хандлагатай болох магадлал үл мэдэгдэхүүнд нэмэгддэг бол хувийн зуслангийн байшинтай болсноор татварын эерэг хандлагатай болох магадлал 17.6%-иар буурч байна. Хувийн зуслангийн байшин нь хүний анхдагч хэрэгцээ биш ба энэ нь ямар нэгэн нэмэлт орлого эсвэл хуримтлал, банк болон бусад ямар нэгэн зээлийн эх үүсвэрээ бий болох боломжтой. Бидний судалгаанд хувийн, зээлээр, түрээсийнх гэх мэтээр ялгаж авсан учир уг зуслангийн байшин нь зээлийн болон бусад эх үүсвэрээр биш гэсэн үг юм. Тиймээс энэ нь одоо эрхэлж буй бизнесийн орлогоос бий болсон хөрөнгө гэж үзвэл уг хөрөнгийг бий болгохын тулд татвараас зайлсхийх хандлага бий болсон байх талтай.
4. *Бусдыг татвараас зайлсхийдэг гэж боддог бол татварын эерэг хандлагыг бууруулж байна.* Бид бусдаас байнга суралцаж, бусдыг үлгэрлэн дуурайн хөгжиж байдаг бол бусдын муу үлгэр дуурайлыг авдаг. Нийгэмд татвараас зайлсхийх хандлага ямар байгаа эсвэл эргэн тойрны найз нөхөд, таньдаг хүмүүс татвараас зайлсхийсэн явдал нь тухайн татвар төлөгчийн татвараас

зайлсхийхэд хүргэдэг байна. Бидний судалгааны үр дүнгээс харвал татвараас зайлсхийсэн хүн бараг байхгүй эсвэл ховор байдаг гэж үзсэн бизнес эрхлэгчдийн татварын хандлага эерэг байх магадлал нь 54.1% бол эсрэг тохиолдолд 50.4% байсан. Уг хоёр магадлалын хувь ойролцоо байгаа нь нөгөө талаасаа компаниуд татварын албанд зориулж хуурамч тайлан гаргадаг гэсэн иргэдийн нийтлэг ойлголтоос үүдэлтэй байж болох юм.

5. *Татварын албаны үйл ажиллагаа нь иргэдийн татварын хандлагад эерэг нөлөө үзүүлдэг байна.*

Татварын албаны үйл ажиллагаа, татварын байцаагчдын ёс зүй, ур чадвар, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж зэргээс татварын эерэг хандлага хамаардаг. Бидний судалгааны үр дүнгээс харвал татварын албанд итгэдэггүй хариулагчдын татварын эерэг хандлагатай болох магадлал 35% бол маш итгэдэг хариулагчдын эерэг хандлагатай болох магадлал 70.6% байна.

6. *Засгийн газраас дэд бүтцийн хөгжил болон боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх нь иргэдийн татвар төлөх хандлагыг нэмэгдүүлдэг байна.*

Иргэд засгийн газраас үзүүлж буй үйлчилгээ, иргэдийн амар тайван амьдрах орчин нөхцөл, зам, тээвэр, түргэн шуурхай шуудан холбоо, боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээ, түүний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх нь иргэдийн татвараа төлөх сэтгэлгээг бий болгодог байна. Энэ нь татвар төлсний хариуд засгийн газраас хүлээдэг хариу төлбөр юм. Уг хариу төлбөр нь маш сайн хийгдсэн тохиолдолд тухайн улсын иргэд татвар төлөхөд харамсах зүйлгүй, стресс бухимдалгүй төлдөг. Орхон аймгийн хувиараа бизнес эрхлэгчдийн хувьд төрөөс үзүүлж буй үйлчилгээнд сэтгэл ханамж муу бол татварын хандлага эерэг байх магадлал бага, сэтгэл ханамж нэмэгдэх тусам татварын хандлага эерэг болох магадлал өсч байна.

7. *Хуульч мэргэжил нь татварын хууль тогтоомжийг зөрчихгүй байх магадлалыг нэмэгдүүлдэг байна.*

Хувиараа бизнес эрхлэгч ямар мэргэжил эзэмшихээс шалтгаалан татварын хандлага эерэг болох магадлал өөр өөр байна. Тухайлбал бизнесийн удирдлагын чиглэл, багш, инженер, эмч гэсэн мэргэжил эзэмших нь татварын хандлагад үзүүлэх нөлөө бараг адилхан бол хуульч мэргэжил нь татварын хандлага эерэг болох магадлал хамгийн өндөр буюу 95.1% байна.

8. *Татварын мэдлэг нэмэгдэхэд татварын эерэг хандлагатай болох магадлал нэмэгдэх боловч татварын талаарх мэддэгч юм шиг, мэддэггүй ч юм шиг иргэд нь эрсдэлтэй байна.*

Татварын талаарх мэдлэг нэмэгдэхэд татвараас зайлсхийх магадлал буурах боловч 40%-60%-ийн мэдлэгтэй хариулагчдын хувьд харьцангуй

өндөр эрсдэлтэй байна. Өөрөөр хэлбэл дунд зэргийн мэдлэгтэй хариулагчийн татварын хандлага эерэг болох магадал нь маш муу мэдлэгтэй хариулагчаас бага байна. Ийм хүмүүс нь татварын талаарх мэддэггүй зүйлээ мэддэг, тухайн нэг татварын нэр төрлийн талаар мэддэг багахан мэдлэгтээ бардаж татварын хууль тогтоомжийг санаатай болон санамсаргүй зөрчих тохиолдлууд их байдаг.

### Дүгнэлт

Орхон аймгийн хувиараа бизнес эрхлэгчдийн татварын хандлагад нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгааг Орхон аймагт бүртгэлтэй татвар төлөгч иргэдээс 330 бизнес эрхлэгч сонгон авч асуулгын аргаар судалгааг авч SPSS програмд боловсруулан үнэлсэн ба татварын хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээг ложит загвар ашиглан хийлээ.

Судалгааны асуулга боловсруулахдаа хөгжиж буй болон хөгжингүй орнуудад татварын хандлагад голчлон нөлөөлж буй гол хүчин зүйлсийг дараах байдлаар асуулгад оруулсан *нийгмийн болон хүн ам зүйн хүчин зүйлсэд* нас, хүйс, гэрлэлтийн байдал, боловсролын түвшин, мэргэжил, *эдийн засгийн хүчин зүйлсэд* бизнесийн орлого, татвараас зайлсхийлт хялбар байдаг эсэх, татварын хувь хэмжээ өндөр эсэх, орон сууцны эзэмшил, хашаа байшинтай эсэх, авто машинтай эсэх, зуслангийн байшинтай эсэх; хувь хүний дотоод хүчин зүйлсэд шашин шүтлэг, эх оронч үзэл, *нийгмийн нөлөөд* арьс өнгө, шашин шүтлэг, яс үндэс, нийгмийн гарлаар ялгаварлан гадуурхдаг эсэх, хүмүүс татвараас зайлсхийдэг эсэх тухай иргэдийн бодол, татварын албанд итгэх итгэл, татварын байцаагчдыг авлага авдаг эсэх талаар бодол; засгийн газрын харну үйлдэл, хүрээлэн буй орчин, зам, цахилгаан эрчим хүч, усан хангамж, шуудан холбоонд сэтгэл ханамжтай байдаг эсэх, боловсролын болон эрүүл мэндийн үйлчилгээнд сэтгэл ханамжтай байдаг эсэх, гэмт хэрэг, зөрчил, троризим, авилга зэргийн илрүүлэлтэд сэтгэл хангалуун байдаг эсэх, ерөнхийлөгч, ерөнхий сайд, засгийн газар, орон нутгийн удирдлагуудын үйл хэрэгтэй санал нийлдэг эсэх, Монгол улс ардчилсан улс гэдэгтэй санал нийлдэг эсэх; *хувиараа бизнес эрхлэгчдийн татварын мэдлэгт*, татварын зөвлөгөө авдаг эсэх, татварын талаар мэдээлэл авдаг эсэх зэргийг хамруулан голчлон нөлөөлнө гэж үзэн судалгааг хийсэн.

Бидний судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Түүвэр судалгаанд хамрагдсан хувиараа бизнес эрхлэгчдийн 46.1% нь сөрөг буюу татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхгүй байх хандлагатай.
2. Татвар төлөгчдийн татвар төлөх хандлагад хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьд хамгийн хүчтэй нөлөө үзүүлдэг хүчин зүйлс нь иргэдийн засгийн газарт итгэх итгэл, шударга байдал, татварын зөрчил илрэх магадлал, татварын мэдлэг байдаг бол манай улсад ч гэсэн энэ хандлага

хадгалагдаж байна.

3. Харин хөгжингүй орнуудын хувьд үндэсний бахархал, шашин шүтлэг, гэрлэлтийн байдал, шууд ардчилал зэрэг нь татвар төлөх хандлагад эерэгээр нөлөөлдөг бол хөгжиж буй орнуудын хувьд эдгээр хүчин зүйлс төдийлөн нөлөөлдөггүй эсвэл энэ чиглэлд хийгдсэн судалгаа хангалтгүй байна. Манай улсын хувьд хөгжиж буй орнуудын хандлага хадгалагдаж байна.
4. Түүнчилэн татварын хувь хэмжээ, орлогын хэмжээ нь татвар төлөх хандлагад сөргөөр нөлөөлдөг буюу тохиолдолд орлого өсөх тусам татварын сөрөг хандлагатай болдог гэсэн хөгжиж буй орнуудын хандлага манай улсад бас ажиглагдаж байна.

#### **Ашигласан материал**

- [1] AfDB 2010a. Domestic resource mobilization for poverty reduction in East Africa: Tanzania
- [2] Case Study. African Development Bank.
- [3] AfDB 2010b. Domestic resource mobilization for poverty reduction in East Africa: Uganda Case
- [4] Study. African Development Bank.
- [5] Allingham, M. G. & A. Sandmo 1972. Income tax evasion: a theoretical analysis. *Journal of Public Economics*, 1, 323-338.
- [6] Alm, J., G. H. McClelland & W. D. Schulze 1992. Why do people pay taxes? *Journal of Public Economics*, 48, 21-38.
- [7] Andreoni, J., B. Erard & J. Feinstein 1998. Tax compliance. *Journal of Economic Literature*, 36, 818- 860.
- [8] Banerjee, A. V. 1992. A simple model of herd behavior. *The Quarterly Journal of Economics*, 107, 797-817.
- [9] Becker, G. 1968. Crime and punishment: an economic approach. *Journal of Political Economy*, 76, 167-217.
- [10] Bodea, C. & A. LeBas 2013. The origins of social contracts: Attitudes towards taxation in urban Nigeria. *CSAE Working Paper WPS/2013-02*. Oxford: Centre for the study of African Economies.
- [11] Cobham, A. 2005. Tax evasion, tax avoidance and development finance. *Queen Elisabeth House Working Paper No. 129*. Oxford: Oxford University.
- [12] Cowell, F. A. 1990. *Cheating the government: The economics of evasion*: The MIT Press.
- [13] Cowell, F. A. & J. P. F. Gordon 1988. Unwillingness to pay: Tax evasion and public good provision.

- [14] *Journal of Public Economics* 36, 305-321.
- [15] D'Arcy, M. 2011. Why do citizens assent to pay tax? Legitimacy, taxation and the African state.
- [16] *Afrobarometer Working Paper No. 126*.
- [17] Drummond, P., W. Daal, N. Srivastava & L. E. Oliveira 2012. Mobilizing revenue in sub-Saharan Africa: empirical norms and key determinants. *IMF Working Paper WP/12/108*. . Washington DC.: International Monetary Fund.
- [18] Fjeldstad, O.-H. 2001. Taxation, coercion and donors. Local government tax enforcement in Tanzania.
- [19] *The Journal of Modern African Studies*, 39, 289-306.
- [20] Fjeldstad, O.-H. & J. Semboja 2001. Why people pay taxes: The case of the development levy in
- [21] Tanzania. *World Development*, 29, 2059-2074.